



АМЕРИК-МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТЭГШ НИЙГЭМЛЭГ

БИД ХЭРХЭН НЭГДЭВ

02

01

Салбар холбооны танилцуулга

Америк-Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Тэгш Нийгэмлэг ГҮТББ /8439249/ нь 2023 оны 11-р сард Америкийн зах зээлээс олон жилийн турш жуулчин хүлээн авч аяллын үйлчилгээ үзүүлж ирсэн туршлагатай тур операторууд нэгдэн нийлж үүсгэн байгуулсан төрийн бус байгууллага юм.

Бидний зорилго


Америк Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Тэгш Нийгэмлэг нь Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсыг зорин ирэх жуулчны урсгалыг нэмэгдүүлэх, АНУ-д Монгол улсыг сурталчлан таниулах, АНУ-н аялал жуулчлалын зах зээл дээр аяллын үйлчилгээ үзүүлэн ажилладаг аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, аяллын үйлчилгээг аюулгүй, өндөр түвшинд үзүүлэхтэй холбоотой ажлуудыг нэгдсэн нэг бодлоготой хамтын хүчээр хийх

Гишүүн байгууллагууд

(47)



УДИРДАХ ЗӨВЛӨЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Тэргүүн Б.Дуламсүрэн
Жамо гранд ХХК



УЗГ Н.Баатарням
Алтан Дөрвөлжин ХХК



УЗГ Б.Саруул
Номадифая ХХК



УЗГ Т.Чулуунцэцэг
Авид зам



УЗГ Б.Тэрэлж
Селена Трэвел ХХК




УЗГ О.Тулга
Номадик Трэйлс ХХК



УЗГ Д.Амартүвшин
Зэндмэнэ тур ХХК

2025 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЯВЦ

Гишүүдийн мэдээлэл, холбооны системийн хүрээнд



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

AMTOURISM.ORG

01

amtourism.org – Вэбсайт хөгжүүлэлт (2025)

❖ АМТА-ийн үндсэн вэб эх сурвалц

Америкийн зах зээлд Монгол Улсыг сурталчлах зорилготой, нэг цул мэдээллийн платформыг бий болгож, *amtourism.org* вэбсайтыг амжилттай хөгжүүлсэн.

❖ Америк хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн сан

Монгол соёл, аялал жуулчлалын онцлог, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн, найдвартай мэдээллийг нэг дор төвлөрүүлсэн.

❖ Гишүүдийн итгэлцлийг нэмэгдүүлэх экосистем

АМТА-ийн баталгаатай, найдвартай гишүүдийг нэг дор байршуулснаар хэрэглэгчдэд шууд итгэх боломж бүрдсэн.

❖ Жижиг компаниудад дэмжлэг үзүүлэх боломж

Вэбсайт нь жижиг, шинээр эхэлж буй аяллын компаниудад “өөрийн сайт”-тай мэт харагдах, өөрсдийгөө сурталчлах платформ болж өгсөн.

❖ Онцгой аяллын бүтээгдэхүүнүүдийг нэг дор танилцуулах боломж

Гишүүн компаниудын өвөрмөц аяллын хөтөлбөрүүдийг хэрэглэгчид нэг дороос харж, сонирхсон тохиолдолд тухайн компанийн вэбсайтад *шууд холбогдох* боломжтой болсон.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

СУРГАЛТ БОЛОН ХӨГЖҮҮЛЭЛТ

02

❖ Вэбсайт хөгжүүлэлтийн сургалт (WIX платформ)

Гишүүн компаниуд өөрсдийн вэбсайтыг бие даан хөгжүүлэх, бүтэц зохион байгуулалт, контентын менежментийг сайжруулах мэдлэг эзэмшсэн.

❖ Ажлын урсгал, зохион байгуулалтын сургалт (Task Management)

Дотоод ажлын хуваарилалт, багийн менежмент, цагийн зохион байгуулалтыг сайжруулах практик арга барилыг зааварласан.

❖ KPI тооцоолол ба гүйцэтгэлийн удирдлага

Компанийн үзүүлэлтүүдийг хэмжих, өсөлт хөгжлөө стратегийн түвшинд төлөвлөх, үр дүнгээ мэргэжлийн түвшинд хянах аргачлал эзэмшүүлсэн.

❖ Вэбсайтын SEO тохиргооны сургалт

Хайлтын системд илүү харагдах, гадаад хэрэглэгчдэд хүрэх боломжийг нэмэгдүүлэх SEO чиглэлийн мэдлэг олгосон.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

USTOA

03

- ❖ USTOA (АНУ-ын Тур Операторуудын Холбоо) нь 1976 онд байгуулагдсан, АНУ-ын аялал жуулчлалын салбарын хамгийн нэр хүндтэй холбоо юм.
- ❖ Энэхүү холбоо нь 1 сая ам.долларын аяллын баталгааны фонд бүхий, аялагчдын эрх ашгийг хамгаалдаг анхны байгууллага бөгөөд зөвхөн өндөр шалгууртай, найдвартай компаниудыг гишүүнээр элсүүлдэг.
- ❖ Жил бүр зохион байгуулагддаг USTOA Annual Conference & Marketplace нь 2025 оны 12-р сарын 1–5-нд АНУ-ын Вашингтоны ойролцоо, Maryland мужид болдог
- ❖ 800+ аялал жуулчлалын удирдах түвшний мэргэжилтэн оролцдог
- ❖ 2024 онд тус холбооны гишүүдийн борлуулалтын нийт дүн \$24.4 тэрбум-д хүрсэн
- ❖ Гишүүн байгууллагуудтай 1:1 уулзалт (Marketplace) хийх боломж олгодог.
(компанид 11 минутын уулзалт бүртгэгдэнэ)

ҮР ДҮН

→ **Америкийн зах зээлд зориулсан албан ёсны нэгдсэн платформтай болсон**

(AMTourism.org – найдвартай, бодит мэдээллийн эх сурвалц)

→ **Гишүүдийн компаниудын брэндиг, борлуулалтын боломж нэмэгдсэн**

(Жижиг компаниуд өөрийн вебийн оронд ашиглах боломжтой)

→ **Гишүүдийн ур чадварын түвшин дээшилсэн**

(Wix хөгжүүлэлт, Task Management, KPI тооцоолол, SEO сургалтууд)

→ **Монгол Улсад USTOA-ын үүд хаалгыг нээсэн**

→ (АНУ-ын зах зээлд Монголын итгэлцэл, нэр хүнд эрс өсөв)

→ **USTOA Annual Conference & Marketplace 2025-д оролцох эрх нээгдсэн**

(1:1 уулзалтууд, 800+ салбарын удирдах түвшний мэргэжилтнүүдтэй холбогдох боломж)

→ **Санхүүгийн ил тод, тогтвортой эхлэл тавигдсан**

(11 сая төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж, шаардлагатай гол зардлуудаа шийдсэн)



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

ХУРАЛ БОЛОН ХИЙСЭН ШИНЭЧЛЭЛТ

2025 ОНЫ ХУРАЛУУД

2025/03/20

Удирдах зөвлөлийн хурал

- Удирдах зөвлөл хуралдаж, байгууллагын бүтэц өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэв
- Шинэ Гүйцэтгэх захирлыг **ТОМИЛОХ** **ШИЙДВЭР** гаргасан

2025/05/2

- Бүх гишүүдийн хурал
- Шинэ удирдах зөвлөлийн гишүүн томилов
- USTOA Annual Conference-т оролцох асуудлыг хэлэлцэж, төлөвлөгөө батлав

2025/06/6

- Удирдах зөвлөлийн хурал
2026 оны төлөвлөгөөг хэлэлцэв
USTOA 2025 бага хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох чиглэлийг ярилцав

2025/11/3

- 2025 оны бүх гишүүдийн хурал



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2025 оны санхүүгийн тайлангын хураангуй мэдээлэл

01

САНХҮҮГИЙН ЭХЛЭЛ

- ❖ Холбооны банкны дансыг 2025 оны 04 сарын 03 албан ёсоор
НЭЭСЭН

02

ОРЛОГО

- ❖ Нийт орлого МТО-оос АМТА-д шилжүүлсэн: 11,000,000 төг
/2024 оны гишүүнчлэлийн төлбөрийн санхүүжилт/

03

ЗАРЛАГА

- ❖ USTOA гишүүнчлэлийн төлбөр- жил бүрийн 1150 USD
- ❖ Вэбсайт хөгжүүлэлт ба домайн хураамж / домайн нэрийн төлбөр,
вэбсайт ажиллуулах үйлчилгээний зардал/




**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гишүүдийн мэдээлэл, холбооны системийн хүрээнд



2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

01

Салбарын дотоод хамтын ажиллагааг бэхжүүлэх

- ❖ Гишүүдийн хоорондын харилцаа, уялдаа холбоог сайжруулах
- ❖ Networking-ийг тогтмол болгох
- ❖ Манай салбарын амжилт 70–80% нь зөв харилцаа, зөв сүлжээнээс хамаардаг.
- ❖ 2026 онд гишүүд бие биетэйгээ илүү ойр байх орон зайг бий болгоно.

02

2026 оны сургалтууд

- ❖ Гадаадын үзэсгэлэнд үр дүнтэй оролцох аргууд
- ❖ Борлуулалтын орчин үеийн хандлага, арга хэрэгсэл (workshop)

2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

WEBINAR

01

Монголын аялал жуулчлалын талаар **цэгцтэй, танин мэдэхүйтэй**
мэдээлэл түгээх

02

Жуулчид болон тур операторуудын **сонирхлыг нэмэгдүүлэх**

03

Монголын аялал жуулчлалыг **мэргэжлийн түвшинд сурталчлах**

2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ASTA

04

- Аялал жуулчлалын зөвлөхүүдэд чиглэсэн сургалт, боловсрол, мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан destination-аа сурталчлах
- Салбар хоорондын хамтын ажиллагаа, сүлжээ, харилцааг бэхжүүлэх
- Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагатай уялдах, мэдээлэлтэй байх
- ASTA-ийн зорилго, үнэт зүйлтэй нийцэж, салбарын дуу хоолойг нэгтгэх, нэр хүндийг нэмэгдүүлэх
- \$2,331 annually

2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ASTA TRAVEL ADVISER CONFERENCE

Travel Advisor Conference 2026 –
Оролцоо

American Society of Travel Advisors
(ASTA)

05

- ❖ 2026 оны Travel Advisor Conference-д **АМТА-ийг төлөөлөн оролцох**
- ❖ Аяллын зөвлөхүүд болон аялал жуулчлалын байгууллагуудтай **B2B харилцаа тогтоох**
- ❖ Монголын аялал жуулчлалыг сурталчлах **материал, танилцуулга хүргэх**
- ❖ АНУ-ын аяллын зөвлөхүүдийн Монгол руу чиглэсэн сонирхол, хамтын ажиллагааг **нэмэгдүүлэх**

2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


USTOA Annual Conference and Marketplace 2026

06

- ❖ **November 30 – December 4, 2026 — Сан Франциско, СА**
АНУ-ын томоохон, олон сая долларын борлуулалттай аяллын
компаниудтай
танилцах, холбоо тогтоох ховор боломж
- ❖ Монголын аялал жуулчлалыг салбарын лидерүүдэд **шууд**
танилцуулах
- ❖ **2025 оны USTOA-д нэгдсэн туршлагадаа тулгуурлан**
дараа жил илүү үр дүнтэй, стратегитай оролцох
- ❖ Зах зээл, бизнесийн шинэ чиг хандлагыг **судалж, Монголд**
нэвтрүүлэх

СТАТИСТИК

Мөн 2025 оны 5-р сарын 1-нээс эхэлсэн Токио Нарита (NRT) – Улаанбаатар (UBN) чиглэлийн улирлын чанартай нислэг нь бидэнд АНУ-ын жуулчдын Монгол руу аялах замыг хялбарчилж, тасралтгүй аяллын урсгал бий болгож байна. Уг нислэг нь долоо хоногт 3 нь удаагийн давтамжтай ба 166 суудал бөгөөд 6 сарын хугацаанд 78 нисэлгийг 70%ийн дүүргэлтээр тооцоход нийтдээ ~9,000 зорчигч тээвэрлэх боломжтой юм. United Airlines-ийн шинэ маршрут нь АНУ-ын жуулчдын тоог ойролцоогоор 50% нэмэгдүүлэх чадавхтай тул бидэнд АНУ-ын зах зээлд өөрсдийгөө танилцуулхад том түлхэц болж буй юм.



СУДАЛГАА


Дэлхийн аялал жуулчлалын салбар цар тахлын дараа хурдан сэргэж байна.

АНУ-ын иргэдийн гадаад руу хийх аялал асар их — жилд бараг 100 сая америк хүн аялдаг.

Монгол улс одоогоор зөвхөн 18,000 америк жуулчин хүлээн авдаг нь бидэнд өсөх, өргөжих их боломж байгааг харуулж байна.

Маркетинг, хамтын ажиллагаа, аялал жуулчлалын үйлчилгээний сайжруулалтаар энэ ашигтай зах зээлээс илүү ихийг татах боломжтой.

АНУ-аас Монголд ирсэн жуулчдын тоо (2023-2026)





**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

БАЯРЛАЛАА

MONGOLIA
· ALWAYS · MOVING ·